

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 05 дугаар сарын
26-ны өдөр

Дугаар 1/236 1/189 ...1/80

Улаанбаатар хот

Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих
арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1, 2.2, 2.3, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.3, 2.3.2, 2.3.4, 2.5.8 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)”-г нэгдүгээр, “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөл”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд даалгасугай:

2.1. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, салбар хоорондын ажлын уялдааг хангах зорилгоор тушаалын гуравдугаар хавсралтаар байгуулагдсан орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд нарт;

2.2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс /Ж.Мягмар/, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/;


2.3. “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөл”-ийг орон нутагт байгуулан батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх, бага насны хүүхдэд эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролын үйлчилгээг цогц байдлаар чанартай үзүүлэх, шаардагдах төсвийг төлөвлөн батлуулж, санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.

3. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх олон улсын сайн загвар, туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлэх, санхүүжилтийн үр ашгийг тооцох аргачлалыг хамтран судалж 2023 оны гуравдугаар улиралд багтаан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар /А.Цолмон /, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газар /А.Хишигбаяр/, Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/ нарт үүрэг болгосугай.

4. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /О.Хуягцогт/, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар /Л.Лувсан/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Батсүх/-т тус тус үүрэг болгосугай.

5. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Чинзориг/-т үүрэг болгосугай.





Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/30 1/30 1/30 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ (2023-2026)

Нэг. Нийтлэг үндэслэл

Улс орны хөгжлийг “хүний хөгжил”-ийн үзүүлэлтээр тодорхойлох болсон энэ цаг үед дэлхийн улс, үндэстэн бүр оюуны хязгааргүй нөөцөд суурилсан хүний хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд амьдрах чадамжтай иргэдийг бэлтгэхэд онцгой анхаарал хандуулж байна.

Хүний амьдралын эхний 1000 хоног буюу ураг бүрэлдэх үеэс 3 хүртэлх насанд хүүхдийн тархи, бие махбод, сэтгэл хөдлөл эрчимтэй хөгжих чухал үе бөгөөд 6 хүртэлх насны хүүхдийн хөгжил, амьдралын туршлага нь түүний амжилттай суралцах, ирээдүйд чанартай амьдрах эх үндэс болдог.

Бага насны хүүхдийн хөгжлийн эрт үед хөрөнгө оруулах нь хувь хүний төдийгүй улс орны эдийн засгийн хөгжилд бүхэлд нь өндөр үр ашиг өгдөг болохыг нотолсон эрдэмтдийн судалгааны дүнд үндэслэн хүүхдийн эрт үеийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхийг дэлхий нийтээр чухалчилж байна.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол хүнийг хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, эрх тэгш байдлыг хангах асуудлыг онцлон авч үзсэн.

Бага насны хүүхдийн бие бялдар, хэл яриа-танин мэдэхүй, сэтгэл хөдлөл-нийгэмшихүйн хөгжил нь түүний амьдрах орчин нөхцөл, эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, хамгааллын байдлаас шууд хамаарах бөгөөд үүнд гэр бүл голлох үүрэг гүйцэтгэнэ.

Энэ үүргийг гүйцэтгэхэд төрөөс хүүхдэд үзүүлж байгаа эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээг нэгдмэл байдлаар хүргэх тусгайлсан бодлого баримтлах, салбар хоорондын нэгдсэн зохицуулалт хамтын хүчин чармайлт, дэмжлэг чухал болж байна.

Иймд Тогтвортой хөгжлийн зорилго (2030)-ын “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд тулгуурлан ургийн үеэс 6 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг цогцоор дэмжих үйлчилгээний нэгдмэл тогтолцоог хөгжүүлэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх шаардлагад үндэслэн бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар дундын арга хэмжээ (2023-2026)-г боловсрууллаа.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1.Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (цаашид “Арга хэмжээ” гэх)-ний зорилго нь хүүхэд бүр эрүүл, аз жаргалтай өсөж, хөгжих тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж, тэдний ирээдүйн амьдралын чанарыг сайжруулахад оршино.

2.2.Арга хэмжээний хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1.бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай, нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх;

2.2.2.гэр бүл, олон нийтэд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх;

2.2.3.бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;

2.2.4.бага насны хүүхдийн цогц хөгжлийг хянах салбар дундын зохицуулалтыг бий болгох.

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхийг тэгш хангасан байх;

3.1.2.нэг ч хүүхдийг орхигдуулахгүй, хүүхэд бүрд тэгш боломж олгосон байх;

3.1.3.хүүхэд бүрийн хэрэгцээ, ялгаатай байдалд тохирсон, уян хатан, соёлын болон жендерийн мэдрэмжтэй байх;

3.1.4.гэр бүлийн үнэт зүйлс, хэл, үндэсний соёл уламжлалыг хүндэтгэн дэмжсэн, хүмүүнлэг, хүний хувийн мэдээллийг хамгаалсан,;

3.1.5.гэр бүл, иргэн, төр, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, хариуцлагад суурилсан байх;

3.1.6.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь цогц, тасралтгүй, хүртээмжтэй байх.

Дөрөв. Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

4.1. Арга хэмжээг 2023-2026 онд хэрэгжүүлнэ.

4.2. Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/-ийг, бүх шатны Засаг даргын дэргэд Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн зөвлөл /цаашид орон нутгийн зөвлөл/-ийг байгуулж ажиллуулна.

4.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтан, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын болон олон нийтийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

4.3.1.Зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад төрийн захиргааны төв байгууллагаас ажиллах албан тушаалтныг тухайн асуудал эрхэлсэн сайдтай зөвшилцөн зөвлөлийн дарга томилон ажиллуулж болно.

4.4. Зөвлөлийн даргыг арга хэмжээ хэрэгжих хугацаанд нь хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн дэд сайд нар ээлжлэн гүйцэтгэх ба орон нутгийн зөвлөлийн дарга нь аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч байна.

4.5. Зөвлөлийн ажиллах дүрмийг тухайн зөвлөл нь батална.

4.6. Зөвлөл нь бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар дундын хамтын ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, үнэлгээ, дүгнэлт өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7. Энэ арга хэмжээний 4.2-т заасан зөвлөл нь арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтийг жил бүр хэлэлцэж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд тайлагнана.

4.8. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, түүний холбогдох нэгж нь бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, гэр бүл, иргэнтэй хамтран ажиллана.

4.9. Арга хэмжээний хэрэгжилтийн эцсийн хөндлөнгийн үнэлгээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хийлгэж, дүнг боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд танилцуулна.

4.10. Арга хэмжээг 0-3 хүртэл насанд эрүүл мэнд-хамгаалал-хөгжил, 3-6 хүртэл насанд боловсрол-эрүүл мэнд-хамгааллын үйлчилгээнд суурилсан хэлбэрээр тус тус хэрэгжүүлнэ.

Тав: Арга хэмжээний санхүүжилт

5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;
- 5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Арга хэмжээний үр дүн

6.1. Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого, төлөвлөлтөд ашиглах салбар дундын мэдээллийн нэгдсэн систем нэвтэрсэн байна;

6.1.2. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарт, сургалтын хөтөлбөр, хүүхдийн хөгжлийг хянах арга хэрэгслийг хөгжүүлсэн байна;

6.1.3. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих гэр бүл, олон нийтэд суурилсан үйлчилгээний загвар бий болсон байна;


6.1.4. Бага насны хүүхэдтэй ажиллах эрүүл мэнд, хамгаалал, боловсролын мэргэжилтэн, сайн дурын ажилтныг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх хөтөлбөр хэрэгжсэн байна;

6.1.5. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд зориулсан хүүхдийн эрт үеийн хөгжлийг дэмжих ном, гарын авлага, сургалтын модуль, платформ, аппликейшн бий болж үйл ажиллагаанд нэвтэрсэн байна;

6.1.6. Бага насны хүүхдийн эрт үеийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалт хийхийн давуу тал, ач холбогдлын талаарх эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн ойлголт, хандлага сайжирч, чадавх дээшилсэн байна.



Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/236 1/189 1/80 дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт



БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн
дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд /2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл/

Эрүүл мэндийн дэд сайд /2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл/

Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд /2025 оны 06 дугаар сарын 01-ээс 2026 оны 12 дугаар сарын 31 -ний өдөр хүртэл/

Зөвлөлийн
 гишүүд:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга

Боловсролын ерөнхий газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн

Зөвлөлийн
нарийн
бичгийн
дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл/

Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга /2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл/

Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга /2025 оны 06 дугаар сарын 01-ээс 2026 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл/



БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт, /хэмжих нэгж/	Суурь түвшин /2022 он/	Хүрэх түвшин	Хугацаа /он/	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага
Арга хэмжээний зорилт 1. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх						
1.1. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих олон хувилбарт үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Хуулийн шинэчилсэн найруулга	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг шинэчлэн найруулж, батлуулсан байна.	2024-2025	ХНХЯ	БШУЯ, ЭМЯ
1.2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар дундын төлөвлөлт, удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	Батлагдсан баримт бичиг	-	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн зөвлөл бүх шатны Засаг даргын дэргэд байгуулагдсан байна.	2023-2024	БШУЯ	ХНХЯ, ЭМЯ
1.3. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх олон улсын сайн загвар, туршлагыг өөрийн орны онцлолт нийцүүлэн хөгжүүлэх, санхүүжилтийн үр ашгийг тооцох аргачлал боловсруулах	Аргачлалын төсөл	-	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих санхүүжилтийн үр ашигтай загвар, аргачлалын төслийг боловсруулсан байна.	2024-2025	ХНХЯ, БШУЯ, ЭМЯ	СЯ, ЭЗХЯ

1.4. Бага насны хүүхдийн аж байдлын судалгаа хийж, үр дүнг бодлого, төлөвлөлтөд ашиглах	Судалгааны тайлан	-	Судалгааг хийж, тайлан, зөвлөмж боловсруулсан байна.	2024-2025	ХНХЯ	БШУЯ, ЭМЯ
1.5. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний олон хувилбарт загварыг иргэд, мэргэжлийн холбоо, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх. (ясли, хүүхэд асрах төв, гэрээр хүүхэд асрагч ажиллуулах, эцэг эх, асран хамгаалагчдын бүлэг гэх мэт)	Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	Хүүхэд харах 142 үйлчилгээний төвд 1626 хүүхэд хамрагдаж байна.	Олон нийтийн оролцоонд суурилсан, сонголттой үйлчилгээний загваруудыг хөгжүүлж, хамрагдах хүүхдийн тоог жил бүр нэмэгдүүлнэ. 2023 онд 1626 2024 онд 3000 2025 онд 4000 2026 онд 5000	2023-2026	ХНХЯ	Олон нийтийн байгууллага
1.6. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих чиглэлээр төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангасан хамтын ажиллагааны үр байгууллагуудын сүлжээг хөгжүүлэх	Сүлжээнд хамрагдсан байгууллагын үйл ажиллагааны үр дүн	Сүлжээ үүсэн байгуулагдсан.	Төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа сайжирна.	2023	БШУЯ	ХНХЯ, ЭМЯ, НҮБ-ын ХС
1.7. Гамшиг, онцгой байдлын үед бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах удирдамж, боловсруулж, батлуулах	Удирдамж	MNS6948:2021 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага стандарт батлагдсан.	Гамшиг, онцгой байдлын үед бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний тасралтгүй байдал хангах удирдамж батлагдсан байна.	2024	ХНХЯ	БШУЯ, ЭМЯ
1.8. Нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшил, бусад байгууллагаас бага насны хүүхдийн хөгжлийг	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тоо, Хөрөнгө	-	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө	2023-2026	ХНХЯ, БШУЯ, ЭМЯ	Олон нийтийн байгууллага

дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих	оруулалтын хэмжээ /төг/	оруулалт жил бүр нэмэгдүүлсэн байна.				
Арга хэмжээний зорилт 2. Гэр бүл, олон нийтэд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх						
2.1. 0-3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйлчилгээнд хамрагдсан 0-3 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлийн тоо	-	Жил бүр 0-3 хүртэлх насны хүүхэдтэй 1000-аас доошгүй гэр бүлд үйлчилгээ, дэмжлэг үзүүлсэн байна.	2023-2026	ГБХЗХГ	Аймаг, нийслэлийн ГБХЗХГ Олон нийтийн байгууллага, иргэд
2.2. 3-6 хүртэлх настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, цогц хөгжлийг дэмжих	3-5 насны нийт хүүхдэд үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	91.2 хувь	2023 онд 91.5 2024 онд 92.0 2025 онд 93.0 2026 онд 95.0	2023-2026	БЕГ	Аймаг, нийслэлийн БШУГ, Цэцэрлэг
2.3. Бага насны хүүхдийн эрт үеийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр болон үйлчилгээний стандарт боловсруулж, хэрэгжүүлэх	Батлагдсан хөтөлбөр, стандарт	Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр батлагдсан.	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарт батлагдсан байна.	2025	БШУЯ	Аймаг, нийслэлийн БШУГ ГБХЗХХ ЭМГ
2.4. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах үйлчилгээний загварыг хөгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих чиглэлээр 37 сургагч багш бэлтгэсэн.	Бүх аймаг, дүүрэгт эцэг, эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах чиглэлээр 30-аас доошгүй сургалт зохион байгуулж, 1000-аас доошгүй хүнийг хамруулсан байна.	2023-2024	ХНХЯ, ЭМЯ, БШУЯ	Аймаг, нийслэлийн БШУГ, ГБХЗХХ, ЭМГ
2.5. Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цагийн болон "хүүхэд асрах чөлөө"-ний уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх зэрэг хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах	Хүүхдэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо	ХНХ-ын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар Хүүхдэд	Хүүхдэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоог жил бүр өмнөх оноос 10-15 хувиар нэмэгдүүлсэн байна.	2023-2026	ГБХЗХГ	Аймаг, нийслэлийн ГБХЗХХ

		хамгааллын бодлого хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1904 байна				
2.6. Бага насны хүүхдэд ажилтанд зориулан хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хөгжлийг дэмжих талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх 5363 эцэг эхийн зөвлөл ажиллаж, 85385 албан хаагчдыг сургалтад хамруулсан.	Жил бүр 30-аас доошгүй сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 3000-аас доошгүй хүнийг хамруулсан байна	2023-2024	ХНХЯ, ГБХЗХГ	Аймаг, нийслэлийн ГБХЗХХ
2.7. Эхийн хэвлийд ураг бүрэлдэх үеэс эхлэн 1000 хоногийн хугацаанд хүүхдийн хөгжлийг хянах, өсөлтийг дэмжих, эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэдийн хувь	-	2023 онд 40-өөс дээш 2024 онд 50-аас дээш 2025 онд 70-аас дээш 2026 онд 90-ээс дээш	2023-2026	ЭМЯ ЭМГ	Өрх, сум, тосгоны ЭМТ Олон нийтийн байгууллага, иргэд
2.8. Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвөөс хүүхдэд үзүүлэх "Гэрийн эргэлт"-ийг эх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн өсөлт, хөгжил, хамгаалалд чиглэсэн цогц үйлчилгээ хэлбэрээр олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулах	Гэрийн эргэлтэд хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн хувь	-	Жил бүр 1,0 хувиар нэмэгдүүлнэ.	2023-2026	ЭМЯ ЭМГ	Өрх, сум, тосгоны ЭМТ Олон нийтийн байгууллага, иргэд
2.9. Бага насны хүүхдийг эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэх үзлэг, хөгжлийн хяналт, дархлаажуулалтад тогтмол хамруулах зан үйлийг эцэг эх, асран хамгаалагчдад хэвшүүлэх, зөвлөгөө өгөх	Хөгжлийн эрт илрүүлэх үзлэг, хөгжлийн хяналт, дархлаажуулалт ад хамрагдсан 0-5 насны хүүхдийн хувь	Дархлаажуулалтад хамрагдсан 0-5 насны хүүхдийн хувь 95,85%	2023 онд 96,0 хувь 2024 онд 96,3 хувь 2025 онд 96,5 хувь 2026 онд 96,8 хувь	2023-2026	ЭМЯ ЭМГ	Эцэг эх асран хамгаалагчид Өрх, сум тосгоны ЭМТ

2.10. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, хоцролтой болон хоцролт үүсэх эрсдэлтэй хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг, эрт үеийн оролцооны хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх	Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны үйл ажиллагааны тоо	-	Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны үйл ажиллагааны тоо нэмэгдэнэ.	2023-2026	ЭМЯ ЭМГ	Өрх, сум тосгоны ЭМТ Олон нийтийн байгууллага, иргэд
2.11. Жирэмсэн үеийн хяналт, эхийн эрүүл мэнд, бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжихэд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан ном, гарын авлага, хэрэглэгдэхүүн, тоглоом наадтайн багц, сургалтын модуль, контент, нээлттэй платформ, аппликейшн хөгжүүлэх, энэ чиглэлээр бий болсон санаачилгыг дэмжих	Арга хэрэгслийг хөгжүүлсэн үр дүн	-	Хүүхдийг ургийн үеэс эхлэн эрүүл байжуулах, гэр бүлийн орчинд хөгжлийг нь дэмжих чиглэлээр бодит болон цахим хэрэглэгдэхүүн, ном гарын авлагыг сонголттойгоор ашиглах боломж бүрдэнэ.	2023-2024	ЭМЯ ЭМГ	Олон нийтийн байгууллага, иргэд
2.12. Хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй болон үндэстний цөөнх, хэл, соёлын ялгаатай бүлгийн хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нээлттэй ашиглах боломжийг бий болгох	Арга хэрэгслийг хөгжүүлсэн үр дүн	-	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлогт нийцсэн, түгээмэл загвар бүхий олон хувилбарт хэрэглэгдэхүүн, гарын авлага бий болно.	2023-2024	ЭМГ БЕГ ХБХХЕГ	БШУЯ ЭМЯ ХНХЯ
2.13. Гэр бүлд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанаас цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд шилжих бэлэн байдал, дасан зохицоход чиглэсэн дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан үйл ажиллагааны хэлбэр, хамрагдсан хүүхдийн хувь	-	Гэр бүлийн орчноос сургалтын байгууллагын орчинд шилжиж буй хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа тогтмолжино.	2023-2026	БЕГ	БШУГ ЕБС, Цэцэрлэг
2.14. Гэр бүлийн төлөвлөлт, эхийн эрүүл мэнд, хүний амьдралын эхний	Олон нийтэд чиглэсэн арга	-	Олон нийтэд чиглэсэн арга хэмжээг жил бүр	2023-2025	ЭМЯ ХНХЯ	Олон нийтийн байгууллага

1000 хоног, хүүхдийг эхийн сүүгээр хооллох, хүүхдийн эрт үеийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, сургуульд бэлтгэх, байгальд ээлтэй, эрүүл амьдралын хэв маягт сурах зэрэг асуудлаар эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хандлага, зан үйлийг хэвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг үндэсний хэмжээнд олон арга хэлбэрээр тодорхой давтамжтай зохион байгуулах	хэмжээний тоо, төрөл		давтамжтай байгуулна.	зохион	ГБХЗХГ ЭМГ	
2.15. Номын сан, хүүхдийн тоглоомын төв, музей, кино театр, худалдаа, үйлчилгээний болон спорт, чийрэгжүүлэлтийн төвд хүүхдийн хөгжлийг дэмжих ээлтэй орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн ААН-ийн тоо	-		Үйлчилгээний газруудад хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжих ээлтэй орчин бүрдэнэ.	ГБХЗХГ	ААНБ
Арга хэмжээний зорилт 3. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх						
3.1. Бага насны хүүхэдтэй ажиллах хүний нөөцөд тавих шаардлага болон хүний нөөцийг бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хүний нөөц бэлтгэх сургалтын хөтөлбөр	-		Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний ажилтан /хүүхэд асрагч/-д тавих шаардлага, бэлтгэх сургалтын хөтөлбөр, баталж хэрэгжүүлнэ.	БШУЯ	ХНХЯ, Эрх бүхий сургалтын байгууллага
3.2. Бага насны хүүхдэд эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролын үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг тусгайлан бэлтгэх	Бэлтгэгдсэн хүүхэд асрах ажилтны тоо	-		2023 онд – 21 Аймаг, нийслэлийн 9 дүүргийн хоол тэжээлийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулна.	БШУЯ ХНХЯ	Эрх бүхий сургалтын байгууллага
3.3. Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтныг нярайн эрт үеийн оношилгоо, хүүхдийн цогц хөгжлийн үзүүлэлтийг хянах арга зүйд сургах, чадавхыг дэмжих	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагаа, хамрагдсан ажилтны тоо	-		Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтныг нярайн эрт үеийн оношилгоо, хүүхдийн цогц хөгжлийн	ЭМЯ ЭМГ	ӨЭМТ

			үзүүлэлтийг хянах арга зүйд сургах сургалтыг жил бүр зохион байгуулсан байна.				
3.4. Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх сайн дурын ажилтан, сургагч багшийг бэлтгэж тогтвортой ажиллуулах	Сайн дурын ажилтны тоо	Сайн дурын ажилтныг бүртгэх цахим бүртгэлийн системийн хөгжүүлэлт хийсэн	Жил бүр 100-аас доошгүй сайн дурын ажилтан бэлтгэж, ажиллуулсан байна.	ГБХЗХГ ЭМГ БЕГ	2023-2024	Олон нийтийн байгууллага	
3.5. Бага насны хүүхдийн асаргаа, эрүүл мэнд, хоол тэжээл, хамгаалал, боловсролын чиглэлээр мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчийг холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажлын байранд суралцах, дадлагдаж боломжийг бүрдүүлэх	Ажлын байранд дадлагдаж байгаа ажиллаж байгаа оюутны тоо /хөтөлбөр тус бүрээр/	Цэцэрлэгийн багшийн ажлын байранд дадлагдаж ажиллаж байгаа оюутны тоо-	Жил бүр 5,0 хувиар нэмэгдүүлнэ.	БШУЯ БЕГ	2023	Холбогдох их, дээд сургууль	
3.6. Бага насны хүүхдийн асаргаа, хөгжил, боловсролын үйлчилгээ үзүүлэх ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулж, хариу арга хэмжээ авах	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан ажилтны хувь	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж буй цэцэрлэгийн багш ажилтны хувь	2024 оноо эхлэн бүрэн хамруулна.	ЭМЯ БШУЯ	2023-2026	Цэцэрлэг, үйлчилгээний байгууллага, иргэн	
3.7. Хөгжлийн бэрхшээл болон хэл, соёлын ялгаатай байдлаас хамаарсан тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг дэмжих багш, ажилтанд зориулсан сургалтын модуль, арга зүйн ном, гарын авлагыг бүтээх, хэвлэн түгээх	Сургалтын модуль, арга зүйн ном, гарын авлагыг хэвлэн түгээсэн байдал	-	Багш, ажилтанд зориулсан сургалтын модуль, багц гарын авлагын хүртээмж нэмэгдэнэ.	БЕГ БСҮХ	2023-2026	Олон нийтийн байгууллага	
Арга хэмжээний зорилт 4. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг хянах салбар дундын зохицуулалтыг бий болгох							
4.1. Бага насны хүүхэд, тэдний гэр бүлийн мэдээллийг агуулсан салбар дундын цахим мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлж, системийг хүүхэд үйлчилгээнээс хоцрох, хөгжлийн	Хөгжүүлсэн цахим систем	-	Салбар дундын "хүүхэд" төвтэй мэдээллийн нэгдсэн системийг үйл	БШУЯ ХНХЯ	2024	ЦХХХЯ, ЭМЯ НҮБ-ын ХС	

хоцролт үүсэхэд хяналт тавих, автоматаар мэдэгдэл/дохно өгөх/ илгээдэг болгох			ажиллагаанд ашиглаж эхэлнэ			
4.2. Хүүхэд бүрийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг хянах үзүүлэлт, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулж, хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц хяналтыг 9, 18, 36, 60 сартайд хийж, мэдээллийн системд бүртгэх	Хяналтад хамрагдсан 9, 18, 36, 60 сартай хүүхдийн хувь	9, 18 сартай хүүхдийн хамрагдалтын хувь 85,0 хувь	Жил бүр 5,0 хувиар нэмэгдүүлнэ.	2023-2026	ЭМЯ ЭМГ	Өрх, сум тосгоны ЭМТ
4.3. Эцэг эх, асран хамгаалагчдад зориулан бага насны хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг хянах арга хэрэгслийг боловсруулж, нэвтрүүлэх	Хяналтын арга хэрэгслийг нэвтрүүлсэн байдал	-	2023 онд арга хэрэгслийг боловсруулна. 2024 онд хэрэгжүүлж эхэлнэ	2023-2024	ЭМЯ БШУЯ	НУБ-ын ХС
4.4. Хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийг үнэлэх жишиг шалгуур үзүүлэлтийг тогтоож, хүүхдийн хөгжлийн үнэлгээг үндэсний түвшинд хийх	Үнэлгээний шалгуур тогтоосон байдал	-	2024 онд шалгуур үзүүлэлтийг тогтооно 2025 онд шалгуур үзүүлэлтээр хүүхдийн өсөлт, хөгжлийн судалгаа хийнэ.	2024-2025	БШУЯ БСҮХ	Олон нийтийн байгууллага
4.5. Бага насны хүүхдийн амьдрах орчны аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах, үйлчилгээний чанарын хяналтыг бий болгох	Үйлчилгээний чанарыг хянах, үнэлэх журам	-	Үйлчилгээний чанарын хяналтын эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2024	БШУЯ ХНХЯ	-

---000---